МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/10 Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгүүд, Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 802 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас цахим системээр хүлээн авах, хянах, олгох, тайлагнах заавар”-ыг 1 дүгээр, “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас”-ны загварыг 2 дугаар, “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас цахим системээр хүлээн авах, хянах, олгох, тайлагнах заавар”-ыг 3 дугаар, “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас”-ны загварыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/79 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү зааврыг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Салбарын хяналтын газар /Б.Мөнхдөл/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад тус тус үүрэг болгосугай.

САЙД Ж.ГАНБААТАР

1508 01 0038

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023
оны .01.... дүгээр сарын 13....-ны өдрийн
А/10.. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС ЦАХИМ СИСТЕМЭЭР ХҮЛЭЭН АВАХ, ХЯНАХ, ОЛГОХ ЗААВАР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх аж ахуйн нэгжид тухайн жилийн батлагдсан ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, зам барилга, инженерийн шугам сүлжээний ажлын батлагдсан зураг төсөл, өрөмдлөг тэсэлгээний ажлын паспортад тусгагдсаны дагуу “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас” олгохтой холбоотой харилцааг зохицуулахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхдээ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.

1.3. “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас олгоно.

1.4. Энэхүү журмыг www.igov.mn цахим системээр “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас” хүссэн хүсэлт хүлээн авч хянах, олгох, тайлагнах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

Хоёр. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас хүссэн албан хүсэлтийг цахимаар хүлээн авч хянах, шийдвэрлэх

2.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас авах хүсэлтийг www.igov.mn цахим системээр хүлээн авах ба цахим хүсэлттэй Сайд танилцаж, төрийн нарийн бичгийн даргад, төрийн нарийн бичгийн дарга Салбарын хяналтын газрын даргад, салбарын хяналтын газрын дарга улсын /ахлах/ байцаагчид даруй шилжүүлнэ.

2.2. Улсын ахлах байцаагч нь хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын цахим системээр ирүүлсэн бичиг баримт нь дараах бүрдлийг хангасан эсэхийг шалгана. Үүнд:

2.2.1. Тэсэлгээний ажил явуулах тухай албан бичиг,

2.2.2. Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийн хуулбар,

2.2.3. Ашигт малтмал эрэх, ашиглах, зам барилга инженерийн шугам сүлжээний ажил эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хуулбар,

2.2.4. Тэсэлгээний ажил явуулах тухай хоёр талын гэрээний хүчин төгөлдөр хуулбар,

2.2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн батлагдсан ашиглалтын үйл ажиллагааны болон хайгуулын ажлын төлөвлөгөө,

2.2.6. Зам барилга, инженерийн шугам сүлжээний ажлын ТЭЗҮ болон магадлан итгэмжлэгдсэн зураг төсөл,

2.2.7. Тухайн аж ахуйн нэгжийн захирлаар батлуулсан тэсэлгээний ажил гүйцэтгэх тэсэлгээний ажлын техникийн тусгай баримт бичиг /төсөл, паспорт/

2.2.8. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр агуулахын байнгын байршлыг холбогдох байгууллагаар нь тогтоолгосон захирамжийн хуулбар,

2.2.9. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүйн бүс тогтоож байнгын үйл ажиллагаанд хүлээн авсан улсын комиссын актын хуулбар,

2.2.10. Уурхай, үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын актын хуулбар,

2.2.11. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахыг хамгаалуулах харуул хамгаалалтын байгууллагатай хийсэн гэрээ, хүчин төгөлдөр гэрчилгээний хуулбар,

2.2.12. Тэсэлгээний ажил гүйцэтгэгчдийг /удирдагч, тэсэлгээчин, туслах, нярав/ тухайн объектод ажиллуулахаар томилсон тушаал, диплом, тэсэлгээний ажил хийх эрхийн болон тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн хүчин төгөлдөр үнэмлэхний хуулбар,

2.2.13. Тэсэлгээний ажлын удирдагч, тэсэлгээчин, туслах, нярав зэрэг албан тушаалтнуудыг даатгалд хамруулсан тухай гэрээ, нотлох баримт,

2.2.14. Тэсэлгээний аюултай бүсийн ойролцоо хүн ам оршин суудаг, цахилгааны болон холбооны шугам дэд станц, үйлдвэрийн барилга, байгууламж, төмөр зам, газар доорх байгууламж зэрэг объект байгаа тохиолдолд холбогдох байгууллагаас тэсэлгээ хийхийг зөвшөөрсөн албан бичиг,

2.3. Баримт бичгийн бүрдэл дутуу, алдаатай ирүүлсэн тохиолдолд тайлбар хэсэгт засварлах шаардлагатай мэдээллийг бичиж, буцаах төлөвт шилжүүлнэ.

2.4. Баримт бичгийн бүрдлийг хангуулахаар буцаасан хяналтын хугацаанд шаардлага хангуулж хариу ирүүлээгүй, ашиглах хяналтын хуудас олгох боломжгүй тохиолдолд цахимаар илгээсэн хүсэлтийн тайлбар хэсэгт үндэслэлийг бичиж, татгалзаж шийдвэрлэнэ.

2.5. Баримт бичгүүдийг хянан үзэж, шаардлага хангасан аж ахуйн нэгжид тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, зам барилга, инженерийн шугам сүлжээний ажлын батлагдсан зураг төслийн дагуу тооцсон тоо хэмжээгээр “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас"-ыг олгоно.

2.6. Аж ахуйн нэгж, байгууллагын цахим системээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

2.7. Холбогдох хууль тогтоомж, энэхүү журам, igov.mn цахим системд зааснаас бусад баримт бичгийг хүсэлт гаргасан этгээдээс шаардахыг хориглоно.

Гурав. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудасны бүртгэл, дугаарлалт

3.1. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудасны бүртгэлийн дугаар нь тухайн хуудас хүчинтэй байх он, хувийн дугаараас бүрдэнэ. Жишээ нь: №23/01 бүртгэлийн дугаарлалтын “23” нь 2023 он, “01” нь ашиглах хяналтын хуудасны хувийн дугаар байна.

3.2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудаст Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын дарга бөгөөд Салбарын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч нар гарын үсэг зурж, Салбарын ерөнхий байцаагчийн болон улсын ахлах байцаагчийн тэмдгээр баталгаажуулна. Салбарын хяналтын газрын даргын эзэнгүй үед түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч гарын үсэг зурж болно.

3.3. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудаст бүртгэлийн дугаар олгох, бүртгэх, архивлах ажлыг тухайн хяналтын хуудсыг бичсэн улсын ахлах байцаагч хариуцах бөгөөд ажлын байрны тодорхойлолтод тусган баталгаажуулна.

3.4. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас олгосон бүртгэл, мэдээг www.portal.igov.mn цахим хуудаснаас татан авч, нэгтгэн дүн шинжилгээ хийж тайлагнах ба мэдээллийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглана.

4. Хариуцлага

4.1. Энэхүү зааврыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

oo0oo

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны .01.... дүгээр сарын 13....-ны өдрийн .A/10.... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС №.../...

Тэсэлгээний ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл: .....ХХК, ...

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: ..... ХХК, ...

Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ: .....

Төслийн баталгаажсан баримт бичиг: ..... хүдрийн /шороон/ ордын 20... оны батлагдсан ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө

Тэсэлгээний ажлын байршил, зориулалт: ..... аймгийн ..... сумын нутагт байрлах ..... хүдрийн ил /далд/ уурхайд

Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт: .....ХХК-ийн агуулахад ..... ХХК-ийн хамгаалалтад хадгална. Агуулахын нярваар..... ажиллана.

№	*Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр*	*Хэмжих нэгж*	*Нийт хэмжээ*	
			тоогоор	*үсгээр*
1				
2				
3				
4				
5				
6				
7				

Тэсэлгээний ажлыг инженер ..... нар удирдан, тэсэлгээчин ..... нар ***"Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"***-ийн заалтуудын дагуу аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж явуулна.

Онцгой нөхцөл: Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл авах тухай бүр орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж байна.

Хүчинтэй хугацаа: 20..../..../....

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
Салбарын хяналтын газрын дарга
бөгөөд Салбарын ерөнхий байцаагч .....

Хяналтын хуудас олгосон:
Улсын ахлах байцаагч .....

Хяналтын хуудас авсан:
"....." ХХК-ийн ажилтан .....

20...-....-....

Дотоодын хяналтыг сайжруулцгаая!

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны ..01..... дүгээр сарын 13....-ны өдрийн А/10..... дугаар тушаалын хавсралт

ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ТЭЭВЭРЛЭХ ХУУДАС ЦАХИМ СИСТЕМЭЭР ХҮЛЭЭН АВАХ, ХЯНАХ, ОЛГОХ ЗААВАР

Нэг .Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг нэг байгууллагаас нөгөө байгууллагад тээвэрлэх хуудас олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудсыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас олгоно.

1.3. Энэ зааврыг www.igov.mn цахим системээр “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас” олгуулах хүсэлт, баримт бичгийг хүлээн авах, хянах, хуудас олгох, тайлагнах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

Хоёр. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас хүссэн албан хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, шийдвэрлэх

2.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас авах хүсэлтийг www.igov.mn цахим системээр хүлээн авна.

2.2. Улсын ахлах байцаагч нь хүсэлт гаргасан иргэн аж ахуйн нэгж, байгууллагын цахим системээр ирүүлсэн дараах баримт бичгийг шаардлага хангасан эсэхийг шалгана. Үүнд:

2.2.1. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл агуулахаас авах, тээвэрлэх тухай аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлт;

2.2.2. ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвөөр баталгаажуулсан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут;

2.3. Баримт бичгийн бүрдэл дутуу, алдаатай ирүүлсэн тохиолдолд тайлбар хэсэгт засварлах шаардлагатай мэдээллийг бичиж засуулахаар буцаах төлөвт шилжүүлнэ.

2.4. Баримт бичгийн бүрдлийг хангуулахаар буцаасан хяналтын хугацаанд хариу ирүүлээгүй, шаардлага хангаагүй тохиолдолд тухайн хүсэлтийг татгалзаж шийдвэрлэнэ.

2.5. Баримт бичгүүд шаардлага хангасан тохиолдолд аж ахуйн нэгжид “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас”-ыг олгоно.

2.6. Улсын ахлах байцаагч нь аж ахуйн нэгж, байгууллагын www.igov.mn цахим системээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 1 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Гурав. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудасны бүртгэл

3.1. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудасны бүртгэлийн дугаар нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудасны дугаар, тээвэрлэх хуудасны хувийн дугаараас бүрдэнэ. Жишээ нь: №23/01-01 бүртгэлийн дугаарлалтын “23/01” нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын

хуудасны дугаар, “01” нь тээвэрлэх хуудасны хувийн дугаар байна.

3.2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудаст улсын ахлах байцаагч гарын үсэг зурж, өөрийн тэмдгээр баталгаажуулна.

3.3. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудаст бүртгэлийн дугаар

олгох, бүртгэх, архивлах ажлыг тухайн хуудсыг бичсэн улсын ахлах байцаагч хариуцна.

3.4. Тээвэрлэх хуудас олгосон бүртгэл, мэдээг www.portal.igov.mn цахим системээс татан авч, нэгтгэн дүн шинжилгээ хийж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү зааврыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

oo0oo

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01..... дүгээр сарын 13.....-ны өдрийн А/110..... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ТЭЭВЭРЛЭХ ХУУДАС № ..../....-.....

Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас: **№ .....**
ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвийн олгосон маршрут: **.....**
Тэсэлгээний ажил гүйцэтгэгч: **..... ХХК**
Тэсэлгээний ажил захиалагч: **..... ХХК, Ил /далд/ уурхай**
Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл олгох агуулах: **..... хот /аймаг/ .....дүүрэг /сум/ ..... ХХК, ... ХХК-ийн агуулахаас**

№	*Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр*	*Марк*	*Хэмжих нэгж*	*Нийт хэмжээ*		*Олгох агуулах*
				тоо	*үсгээр*	

Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийг **..... ХХК** гүйцэтгэнэ.

Тээвэрлэх хуудас олгосон:
Улсын ахлах байцаагч .....

Тээвэрлэх хуудас авсан:
..... ХХК-ийн ажилтан .....

Олгосон огноо: 20....-....-....